



**Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн
2025 онд төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл,
нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд
хэрэгжүүлсэн ажлын тайлан**

2025.12.23

Улаанбаатар хот

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь нийт 478 орон тоотойгоор хүн амд сэтгэц, нийгмийн сэргээн засах тусламж үйлчилгээг хүргэн ажиллаж байгаа бөгөөд Эрүүл мэндийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 15-ний өдрийн А/394 дүгээр “Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дүрэм, бүтцийг шинэчлэн батлах тухай” тушаалаар ДҮРЭМ, БҮТЭЦ шинэчлэн батлагдсан.

2025-2028 онд хэрэгжүүлэх Хүний нөөцийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг төвийн Захирлын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/287 дугаар тушаалаар, Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/288 дугаар тушаалаар тус тус шинэчлэн баталсан ба ажиллагсдын хэрэгцээ шаардлагад үндэслэн хэрэгжилтийн төлөвлөгөөг жил бүр боловсруулж ажиллахаар төлөвлөгдсөн.



2025 оны хувьд албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр дараах ажил, арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна.

1.АЖИЛТНЫ ГАДААД ДОТООДЫН СУРГАЛТЫГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР:

- Эмч эрүүл мэндийн ажилтны мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх, чадвахжуулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр БНТУ-д хүүхдийн Аутизмын оношилгооны “ADOS-2” хөтөлбөрийн дадлагажуулах сургалтанд хамрагдсан ХӨҮК-ийн эрхлэгч эмч Л.Цэрэндолгор, үзлэгийн эмч Б.Азбаяр, Х.Цэндсүрэн, Сэтгэц, нийгмийн эрүүл мэндийн албаны ахлах мэргэжилтэн Е.Гүлжанат, амбулаторийн үзлэгийн эмч ШСугармаа нарт нийт 5,000,000 төгрөгийн дэмжлэг;



- ЭМТҮЧАБА-ны дарга Д.Одончимэгийн Солонгос улсад болсон ОУ-ын хуралд оролцоход 1,291,500 төгрөгийн;
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цахимжуулах шийдлийг гаргах, урт хугацааны тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн даатгал зохицуулалтын албаны ахлах эмч Л.Уянгыг Тайвань улс уруу сургалтанд оролцох тийзний зардалд 2,500,000;
- ХНХА-ны мэргэжилтэн Б.Сарангэрэлийн “Зөөлөн ур чадвар”ын сургалтанд хамруулж 16,800,000 төгрөгний дэмжлэгийг төсвөөс гаргасан./ЭМЯ-ны дэмжлэг

2.АЖИЛТНЫ ГЭР СУУЦНЫ АСУУДАЛ, БУЦАЛТГҮЙ ТЭТГЭМЖ ОЛГОХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

- Сэтгэцийн эмгэг судлалын нэгдүгээр клиникийн туслах сувилагч Энхбатын Мөнх-Эрдэнэ, Донтох эмгэг судлалын клиникийн туслах сувилагч Шүхэртийн Одгэрэл нарт тус бүр 9,070,000 төгрөгийн үнэ бүхий иж бүрэн Монгол гэр,



- Гал түймрийн улмаас орон гэргүй болсон Шүүх сэтгэцийн эмгэг судлалын клиникийн туслах сувилагч Д.Батхуягийн гэр бүлд 6,980,00 төгрөгийн үнэ бүхий бүрэн тавилгатай монгол гэрийг хүлээлгэн өгсөн.



- Эрүүл мэндийн болон бусад шалтгааны улмаас ажлын байраа солих хүсэлт гаргасан 8 ажилтныг хүсэлтийнх нь дагуу ажлын байрыг сольж ажиллуулсан.
- Ажилтны нийгмийн баталгааг сайжруулах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр 27 ажилтанд 7,850,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмж ;
- Өндөр настны тэтгэврээ тогтоолгосон 5 ажилтанд эрүүл мэндийн хуулийн 29.2 дахь заалтын дагуу 140,212,039 төгрөгийн тэтгэмж;
- Төрийн дээд одон медаль, Салбарын шагналаар шагнагдсан ажилтны дагалдах мөнгөн шагнал болон нийгмийн баталгааг сайжруулах, урамшууллын зардалд 157,957,325 төгрөгийг тус тус зарцуулсан байна.

3.ХАБЭА-Н ЧИГЛЭЛЭЭР:

- Ажилтан бүрт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн мэдлэгийг олгож, аюулгүй ажиллах соёлыг эзэмшүүлэх зорилгоор СЭМҮТ-ийн Хүний нөөц, хөгжлийн алба нь “Ололт-амжилтын түлхүүр” сургалтын төвтэй хамтран Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)-н сургалтыг 2025 оны 6 дугаар сарын 19, 20-ны өдрүүдэд зохион байгуулсан.
- Сургалтад СЭМҮТ-ийн 250 гаруй ажилтан хамрагдсан бөгөөд сургалтыг Олон улсын стандартын тэргүүлэх аудитор, сургагч багш Б.Батхүү, Дотоод стандартын аудитор, гамшгийн үнэлгээний мэргэжилтэн, сургагч багш Г.Итгэл болон СЭМҮТ-ийн Хүний нөөц, хөгжлийн албаны мэргэжилтэн М.Даваадулам нар удирдан явуулсан юм.

- Уг сургалтад хамрагдсанаар ажилтнууд ХАБЭА-н тухай хуулийн мэдлэгээ бэхжүүлж, үйлдвэрлэлийн осол буюу ажлын байран дахь аюулыг илрүүлэх, мэдээлэх, урьдчилан сэргийлэх ойлголтоо нэмэгдүүлснээс гадна галын аюулгүй байдал, онцгой байдлын үед хариу арга хэмжээг хэрхэн авах талаар онолын мэдлэгээ бататгасан.
- Эрсдэл бүхий ажлын байр болон дарарлтат савны аюулгүй ажиллагааны талаар Төвийн ХХҮТ, ИТЭТА, Яаралтай тусламжийн нийт ажилтнуудад “Эрсдэлтэй ажлын байрны сургалт”-ыг Ололт амжилтын түлхүүр” ХХК-тай хамтран зохион байгуулж, үнэмлэх олгосон. ХАБЭА-н талаар мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, өөрсдийн хүлээх, үүрэг хариуцлагын талаарх мэдлэгийг бататгасан.



Үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг судлан бүртгэх комиссын бүрэлдэхүүнийг Захирлын 2025.03.19-ний өдрийн А/82 дугаар тушаалаар баталгаажуулсан ҮОХХСБК-ын ажиллах журмыг Захирлын 2025.06.13-ны өдрийн А/190 дүгээр тушаалаар шинэчлэн баталж, журмын дагуу ажиллаж байна

4.АЖИЛТНУУДАА УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭНД ХАМРУУЛАХ, ЭРҮҮЛЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- Ажилтнуудынхаа эрүүл мэндийг хамгаалах, эмгэгийг эрт илрүүлэх зорилгоор Хавдар судлалын үндэсний төвтэй Хавдар судлалын үндэсний төв хамтран

хэрэгжүүлж, ажилтнуудаа толгой, хүзүүний хавдрын оношилгоо, шинжилгээнд хамрууллаа.



И-Монос / Ундрам хан хангай ХХК/ нь нийгмийн хариуцлагын хүрээнд эрүүл мэндийн үзлэг оношилгоо СЭМҮТ -н албан хаагчдын цаг завьг хэмнэн ажлын байран дээр нь 2025.05. 29-30- ний өдөр 93 ажилтныг эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамрагдлаа. Нийт ажилчдын 60,2% нь эрдэс, витаминь дутагдалтай, 53,4% нь Д- витаминь дутагдалтай. Шүд : 32 хүн үзүүлсэнээс эмчилгээ хийлгэх шаардлагатай-18, чулуу-16, цоорол-18. Хеликобактерийн шинжилгээнд 35 хүн хамрагдсанаас нь 14 эерэг ба 37,2% нь хеликобактеритэй гарсан.Иймд нарийн мэргэжлийн эмч нар зөвлөгөө өгөн, тохирох эмчилгээ жороор бичин олгох ажлыг зохион байгуулсан.



А. Монголжин
5-р сарьнын 30

Өдрийн мэндээ.

Яг одоо дараах оношилгоонууд хийгдэж байна.
Өнөөдөр 15 цаг хүртэл үзлэг хийгээд дуусах тул яаравчлаарай.

#ЭРДЭС ВИТАМИНЫ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ

#ШҮДНИЙ ЭМЧИЙН ҮЗЛЭГ эдгээр үзлэг үнэ төлбөргүй хийгдэнэ.

НЭМЭЛТЭЭР:

#АРЬСНЫ ҮЗЛЭГ ОНОШИЛГОО-10.000 төг

#ХЕЛИКОБАКТЕРИЙН ТҮРГЭВЧИЛСЭН ШИНЖИЛГЭЭ-13.500 төгрөгөөр хийгдэх юм байна.

ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ТАСГИЙН ТУСГААРЛАХ ХЭСГИЙН ХААЛГААР ОРЖ ҮЙЛЧИЛГЭЭ АВНА УУ.

emornos HOME BEAUTY


PUREMI 2.0
АРЬС ОНОШИЛГООНЫ
АППАРАТ

Хиймэл оюун ухаанд суурилсан уг арьс оношилгооны аппарат нь таны арьсны онцлог, түүнд тохирсон арчилгаа, жэрэгтэй бүтээгдэхүүн зэргийг өндөр нарийвчлалтайгаар тооцоолон гаргах бөгөөд үрчлээний түвшин, батга, нүхжилт хуурайшилт, нөсөө толбо зэрэг 10 гаруй төрлийн оношилгоог хийнэ.

emornos www.emonos.mn 1800-1883 24 ЦАГИЙН ХҮРГЭЛТ

Урьдчилан сэргийлэх үзлэгийн хүрээнд 2025.12.15-19-ний өдрүүдэд 151 ажилтанд цус, шээс, биохмийн шинжилгээ авч хэвлийн хөндийн эхо үзлэг, зүрхний цахилгаан

бичлэг хийн, шаардлагатай нарийн мэргэжлийн эмчийн үзлэг болон эрүүлжүүлэх эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулсан.



5.АЖЛЫН БАЙРНЫ ТААТАЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- Ажилтны ажиллах тав тухтай орчин бүрдүүлэх зорилгоор клиник, тасаг, хэсгүүдэд 363,994,503 төгрөгний урсгал засвар хийгдсэн.



6.ЦАЛИН ХӨЛСИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- Удирдлагын зөвлөл, СЭМҮТ-ийн ҮЭХ-ны хороотой байгуулсан хамтын гэрээний дагуу ажилтны нийгмийн баталгаа сайжруулах чиглэлээр унааны мөнгийг 3000, хоолны мөнгийг 12,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн.
- Цэвэрлэгээ үйлчилгээ хийдэг туслах сувилагч болон үйлчлэгч нарт цэвэрлэгээ үйлчилгээний нэмэгдэл хөлсийг үндсэн цалингийн 0,5 хувиар бодож сар бүр олгодог болсон.

7.АХМАД НАСТНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, НИЙГМИЙН БАТАЛГААГ САЙЖРУУЛАХ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

- Гавъяаны амралтандаа гарсан ажилтнуурынхаа хөдөлмөр эрхлэх бололцоогоор ханган, 10 сувилагч, 1 туслах сувилагч, 4 эмчийг ажлын байраар ханган ажиллуулж байна.
- Ахмадууддаа хүндэтгэл үзүүлэн “Амадын баярын өдөр”-ийг тохиолдуулан 250 ахмад ажилтнаа хүлээн авч, 26 ахмад ажилтандаа салбарын шагнал, нийт ахмадууддаа дурсгалын зүйл гардуулах үйл ажиллагааг зохион байгуулж 20,142,000 төгрөгийг зарцуулсан.



Тайлан бичсэн: ХНХА-ны ахлах мэргэжилтэн

М.Даваадулам